



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/1446

Улаанбаатар хот

Газар эзэмшүүлэх эрхийн зориулалт,
хаяг өөрчлөх, хамтран эзэмшигч хасах,
нэмэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 32.7, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 33 дугаар зүйлийн 33.1.1, 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Газрын харилцаа геодези зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам", Нийслэлийн Засаг даргын 2020 оны Б/91 дүгээр захирамж, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 10/09 дүгээр тогтоол, дүүргийн "Газар эзэмших, ашиглах эрхийг хянан шийдвэрлэх дэд зөвлөл"-ийн 2021 оны 09 дугаар сарын 29-ний өдрийн хурлын дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн зориулалт, хаяг өөрчлөх, хамтран эзэмшигч хасах, нэмэх тухай ирүүлсэн 3 (гурав) иргэн, хуулийн этгээдийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хавсралтад заасны дагуу өөрчилсүгэй.

2. Энэ захирамж гарсантай холбогдуулан Дүүргийн Засаг даргын 2019 оны А/286 дугаар захирамжийн иргэн Х.Чинбаатар, 2020 оны А/574 дүгээр захирамжийн иргэн Д.Ганчимэг, Дүүргийн Засаг даргын 2019 оны А/481 дүгээр захирамжийн Хөтөлтэлмэн ХХК, Дүүргийн Засаг даргын 2019 оны А/284 дүгээр захирамжийн иргэн А.Энхтөр нарт холбогдох хэсгийн газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээг хүчингүй болсонд тооцсугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй холбогдох хууль тогтоомж, журмын дагуу гэрээ байгуулж, газрын улсын бүртгэлд бүртгэх, гэрчилгээ олгон, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Д.Энхтөр)-нд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.СУМЪЯАБААТАР



Баянгол дүүргийн Засаг даргын
2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
Ажлын дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ЭРХИЙН ЗОРИУЛАЛТ, ХАЯГ, ХАМТРАН
ЭЗЭМШИГЧ НЭМЭХ, ХАСАХ ТУХАЙ

Д/д	Газар эзэмшигч, ашиглагч иргэн, ахуйн байгууллагын нэр	Регистрийн дугаар	Газрын байршил /хороо/	Зориулалт /код/	Хэмжээ /м2/	Хугацаа	Эдэлбэрийн хэлбэр	Өмнөх зориулалт, хаяг, нэр	Өмнөх шийдвэр	Нэгж талбарын дугаар
1	Мөнхжин овогтой Ханджавын Чинбаатар	ХЗ80021575	20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс-4 /16103/	Аж ахуй	3997	15	Эзэмшүүлэх	О.Бат-Эрдэнэ, Х.Чинбаатар	2019 оны А/286	1681910053
2	Жалайр овогтой Доржбалын Ганчимэг	УС83062429	20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс-4 /16103/	Гэр бүлийн хамтын хэрэгцээний	524	15	Эзэмшүүлэх	М.Билгүүнжаргал, Д.Ганчимэг	2020 оны А/574	1681910228
3	Дамбынхан овогтой Алтанхүүгийн Энхтөр	ЧР81060117	20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс-2 /16101/	Үйлдвэрлэл	312	15	Эзэмшүүлэх	Гэр бүлийн хамтын хэрэгцээний	2019 оны А/284	1681810044